



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/02

Бат-Өлзий сум

Цэргийн бүртгэл явуулах тухай.

Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх заалт, 34 дүгээр зүйл, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Засаг даргын “Цэргийн бүртгэл явуулах тухай” 2024 оны 1 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны цэргийн бүртгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 05-наас 2023 оны 01 дүгээр сарын 19-ний хооронд биечлэн болон цахимаар зохион байгуулсугай.

2.Цэргийн бүртгэл явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.
Ажлын хэсгийн дарга: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Ж.Нямтогтох (1 дүгээр багийн Засаг дарга)
Д.Бямбасүрэн (2 дугаар багийн Засаг дарга)
С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)
Г.Пүрэвтогтох (4 дүгээр багийн Засаг дарга)
Г.Бямбагарав (5 дугаар багийн Засаг дарга)
Д.Дэмиддагва (6 дугаар багийн Засаг дарга)
Ц.Баасанжав (Насан туршийн боловсролын арга зүйч)
Ө.Гөлгөө (Улсын бүртгэгч)
Д.Доржханд (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)
Б.Орбиш (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

3.Цэргийн бүртгэлийг зохион байгуулахдаа иргэдэд зар мэдээллийг хүргэн, иргэний цахим үнэмлэх, цэргийн үүрэгтний үнэмлэхийг үндэслэн биечлэн болон “e-Mongolia” гар утасны аппликейшнээр бүртгэхийг багийн Засаг дарга (Ж.Нямтогтох, Д.Бямбасүрэн, С.Төмөр, Г.Пүрэвтогтох, Г.Бямбагарав, Д.Дэмиддагва) нарт үүрэг болгосугай.

4.Цэргийн бүртгэлийг Засаг даргын Тамгын газрын багийн Засаг дарга нарын ерөөнд заасан хугацаанд заавар журмын дагуу явуулж, дүн мэдээг 2024 оны 02 дугаар сарын 06-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт хүлээлгэн өгөхийг ажлын хэсгийн ахлагч (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

5.Цэргийн бүртгэл зохион байгуулахад шаардагдах 500,000 (Таван зуун мянган) төгрөгийг Засаг даргын нөөцөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

2024.01.10